

**Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний  
хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн**  
(2023 оны жилийн эцсийн байдлаар)

***Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго***

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 23 дугаар тогтоолоор Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө батлагдсан.

Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний Өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг нэвтрүүлэн, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна Зорилго 1.3-ын хүрээнд Эрүүл мэндийн яам үндсэн хэрэгжүүлэгч байгууллагаар нийт 18 арга хэмжээ, Боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхэд бүрийг тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлэх Зорилго 1.1-ын хүрээнд Боловсрол, шинжлэх ухааны яамтай хамтран хэрэгжүүлэх 1 арга хэмжээ, нийт 19 арга хэмжээ тусгагдсан байна.

Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө 2023 онд эрүүл мэндийн салбараас хэрэгжүүлэх арга хэмжээ, хүлээгдэж буй үр дүндээ хүрсэн эсэхийг нягтлах, арга хэмжээ тус бүрийн хүрсэн түвшинг тодорхойлох, шаардлагатай санал, зөвлөмжийг боловсруулах, шийдвэр гаргагч нарт холбогдох мэдээлэл өгөх зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж гүйцэтгэсэн болно.

***Хоёр. Хяналт-шинжилгээ үнэлгээний арга зүй***

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу үнэлгээг хийж, журмын дөрөвдүгээр хавсралт ёсоор тайланг нэгтгэн гаргасан. Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний арга хэмжээ тус бүрийн хэрэгжилтийг журмын 6.2.2, 6.2.3 дугаар заалтад заагдсан бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлэх аргачлалыг баримтлан арга хэмжээний хэрэгжилтийн хувиар тооцон гаргасан.

***Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн***

Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан эрүүл мэндийн салбарын 19 арга хэмжээний хэрэгжилт 2023 оны жилийн эцсийн байдлаар 47.1 хувьтай үнэлэгдсэн.

“Үр дүнтэй” буюу 100 хувийн үнэлгээтэй 4 арга хэмжээ;

1. 1.1.7.1. Стандартад нийцсэн хоолны газартай сургуулийн эзлэх хувь (НЭМГ, СХГ);
2. 1.3.1.1. “Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний хэрэгжилт, хувиар (НЭМГ);
3. 1.3.1.5. “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” арга хэмжээний хэрэгжилт, хувиар (НЭМГ);
4. 1.3.3.2. Телемедицин нэвтрэх эрүүл мэндийн байгууллагын тоо (БТГ).

*“Тодорхой үр дүнд хүрсэн”* буюу 77.0-89.6 хувийн үнэлгээтэй 4 арга хэмжээ;

1. 1.3.1.2. “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээний хэрэгжилт, хувиар (НЭМГ);
2. 1.3.1.3. “Харшлаас сэргийлэх” арга хэмжээний хэрэгжилт, хувиар (НЭМГ);
3. 1.3.1.4. “Элэг бүтэн Монгол” арга хэмжээг хэрэгжүүлж, Д вирустэй иргэдийг эмчилгээнд хамруулах ажлын явц, хувиар (ЭТҮГ);
4. 1.3.2.8. Шинээр барих болон өргөтгөх нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвийн тоо (СЭЗГ).

*“Эрчимжүүлэх шаардлагатай”* буюу 60 хувийн үнэлгээтэй 1 арга хэмжээ байна.

Үүнд:

1. 1.3.1.6. “Хавдрын эсрэг” арга хэмжээний хэрэгжилт, хувиар (НЭМГ).

*“Эрчимжүүлэх шаардлагатай”* буюу 50 хувийн үнэлгээтэй 2 арга хэмжээ байна.

Үүнд:

1. 1.3.2.4. Геронтологийн төвийн барилгын ажлын явц, хувиар (СЭЗГ);
2. 1.3.3.1. Мэдээлэл солилцооны платформ нэвтрүүлэх ажлын явц, хувиар (БТГ).

*“Үр дүнгүй”* буюу 0 хувийн үнэлгээтэй 8 арга хэмжээ байна. Үүнд:

Орчин үеийн стандартад нийцсэн эмнэлгийн тоог нэмэгдүүлж, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгын хүрээнд:

1. 1.3.2.1. Сүрьеэгийн эмнэлгийн барилгын ажлын явц (СЭЗГ);
2. 1.3.2.2. Зүрх судасны төвийн барилгын ажлын явц (СЭЗГ);
3. 1.3.2.3. Эрхтэн шилжүүлэн суулгах төвийн барилгын ажлын явц (СЭЗГ);
4. 1.3.2.5. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн цогцолбор салбар II-ын барилгын ажлын явц (СЭЗГ);
5. 1.3.2.6. Хавдар судлалын үндэсний төвийн салбар-II-ын барилгын ажлын явц (СЭЗГ).
6. 1.3.2.7. Баянзүрх дүүрэг дэх 300 ортой эмнэлгийн барилгын ажлын явц (СЭЗГ);
7. 1.3.2.9. Өвчний хяналт, зохицуулалтын төвийн барилгын ажлын явц (СЭЗГ);
8. 1.3.4. Эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудын ариун цэврийн байгууламжийг орчин үеийн стандартад нийцүүлэн шинэчлэх (СЭЗГ).

Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний 11 арга хэмжээнд нийт 311,522.5 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэл хэрэгжүүлэхэд 55,076,808,621 төгрөг, төгрөг байна(17.7%). Үүнд:

- “Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээг хэрэгжүүлэхэд 1,101,052,083 төгрөг, Эрүүл мэндийг дэмжих сан, НҮБ-ын ХАС, Хүүхдийн сан, ДЭМБ;
- “Харшлаас сэргийлэх” арга хэмжээг хэрэгжүүлэхэд 30.1 сая төгрөг, Эрүүл мэндийг дэмжих сан;
- “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” арга хэмжээг хэрэгжүүлэхэд 8,752,145,538 төгрөг, Япон Улсын Засгийн газар, ДЭМБ, НҮБ-ын Хүүхдийн сан, АХБ;
- “Элэг бүтэн Монгол” арга хэмжээг хэрэгжүүлэхэд 13,500,000,000 төгрөг, улсын төсөв;

- Шинээр барих болон өргөтгөх нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвийн барилга арга хэмжээнд нийт 113,624.50 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас 2023 оны жилийн эцсийн байдлаар гүйцэтгэл 31,693,500,000 төгрөг (улсын төсөв) байна.

Үр дүнгүй байгаа арга хэмжээ нь бүгд хөрөнгө оруулалттай холбоотой бөгөөд санхүүжилт батлагдаагүйгээс хэрэгжээгүй байна. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд санал хүргүүлсэн боловч батлагдаагүй болно.

### ***Дөрөв. Дүгнэлт***

1. Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан эрүүл мэндийн салбарын 19 арга хэмжээний хэрэгжилт 2023 оны жилийн эцсийн байдлаар 47.1 хувь буюу “Эрчимжүүлэх шаардлагатай” гэсэн үнэлгээтэй байна.

2. Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан эрүүл мэндийн салбарын арга хэмжээний хэрэгжилтэд нийт 55,076,808,621 төгрөгийг улсын төсөв, Япон Улсын Засгийн газар, ДЭМБ, НҮБ-ын Хүн амын сан, Хүүхдийн сан, АХБ-аас зарцуулсан байна.

3. “Үр дүнгүй” гэсэн үнэлгээтэй 8 арга хэмжээ нь хөрөнгө оруулалтын арга хэмжээ бөгөөд Монгол Улсын 2023 оны төсвийн төсөл болон гадаадын, зээл тусламжийн хөрөнгөөр шийдвэрлэх саналыг Сангийн яам болон Эдийн засаг, хөгжлийн яаманд тус тус хүргүүлсэн боловч батлагдаагүй байна.

4. Цаашид зураг төсөв батлагдаагүй, холбогдох тооцоо, судалгаагүй арга хэмжээг бодлогын баримт бичигт тусгахгүй байх.

5. Арга хэмжээг хэрэгжүүлэхдээ зарцуулсан санхүүжилт, эх үүсвэрийг тайлагнахгүй орхигдуулсан хэвээр байна.

### **Тав. Зөвлөмж**

1. Цаашид зураг төсөв батлагдаагүй, холбогдох тооцоо, судалгаагүй арга хэмжээг бодлогын баримт бичигт тусгахгүй байх;

2. Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зарцуулсан санхүүжилтийг тодорхой, эх үүсвэрийн хамт тайлагнаж байх, тайлагналтад тавих хяналтыг сайжруулахыг газар, хэлтсийн дарга анхаарах.

Эрүүл мэндийн яам  
Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар  
2023 оны 12 дугаар сарын 25